



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 671

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.б дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын хөрөнгө оруулалтаар хийгдсэн, 12 нэрийн нийт 41,539,020,386.00 (дөчин нэгэн тэрбум таван зуун гучин есөн сая хорин мянга гурван зуун наян зургаа) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу орон нутгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.“Эрдэнэс Монгол” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын ерөнхий захирал Г.Ёндөн болон хавсралтад заасан орон нутгийн өмчийн газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үйлдвэрийн газрын хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтад оруулсан хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргaa, зориулалтыг харгалзан, эзэмшигч байгууллагыг тогтоох асуудлыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулан шийдвэрлүүлэх;


2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу эзэмшигч байгууллагын нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3.Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Байгууламжийн доорх газар эзэмших эрхийг хөрөнгө хүлээн авсан байгууллагын нэр дээр баталгаажуулах, шилжүүлэх;

2.5.Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үдрэг болгосугай.



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн
07/ дугаарт тогтоолын хавсралт

“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР БИЙ БОЛСОН,
ОРОН НУТГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хөрөнгийн нээ (төгрөг)	Барилга байгууламж ашиглалтад оруулсан улсын комиссын актын дугаар	Хүлээн авч бүртгэх аймаг, төрийн өмчит байгууллага
1	Эрдэнээт - Хялганат чиглэлийн 64 км авто зам	2023	4,070,981,233.00	AЭЗ-05/2023	Орхон аймгийн Орон нутгийн өмчийн газар
2	Эрдэнээт - Хялганат чиглэлийн 64 км авто зам	2023	26,516,127,272.00		
3	Ус өргөх 1, 2-р станц чиглэлийн авто зам	2023	3,455,636,837.00		
4	Цэвэрлэх байгууламж чиглэлийн авто зам	2023	2,136,863,640.00		
5	Гүүр №1 (Хуурайн булгийн)	2023	446,881,776.00		
6	Гүүр №2 (Цуврайгийн голын)	2023	576,385,049.00		
7	Гүүр №3 (Талт усны)	2023	456,009,903.00		
8	Гүүр №4 (Чулгуутын голын)	2023	577,767,471.00		
9	Гүүр №5 (Сөртийн голын)	2023	581,115,817.00		
10	Гүүр №6 (Зөөхийн голын)	2023	710,047,108.00		
11	Гүүр №7 /Галтайн голын/	2023	579,093,312.00		
12	Гүүр №8 (Цулхарын голын)	2023	1,432,110,968.00		
	НИЙТ ДҮН		41,539,020,386.00 (дөчин нэгэн тэрбум таван зуун гучин есөн сая хорин мянга гурван зуун наян зургаа)		